



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/153

Улаанбаатар хот

Г ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын
ахлах сургуулийн элсэлтийн
журам батлах тухай Г

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ын 3.3 дахь заалт, ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн үйл ажиллагааг зохицуулах журмын 7.5, 7.6 дахь заалт, ахлах сургуулийн захирлын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

- “ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн элсэлтийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2023 оны 05 дугаар сарын 05 -ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
- “ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн элсэлтийн журам”-ыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал (Д.Нямсүрэн), Дарханы Технологийн сургуулийн харьяа Ахлах сургуулийн захирал (Ц.Батбаатар) нарт үүрэг болгосугай.



367040735

UNIVERSITY OF

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05 сарын 02-ны
өдрийн 153 дугаар тушаалын хавсралт



	ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн элсэлтийн журам ШУТИС-СҮ-ЖУ12	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2018 он 2023 он 6
--	---	--	-------------------------

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Боловсруулсан:

ШУТИС-ийн харьяа Ерөнхий Боловсролын Ахлах Сургууль
Дарханы Технологийн сургуулийн харьяа Ахлах сургууль

Хянасан:

Сургалт, цахим шилжилтийн газар
Хяналт, шинжилгээ дотоод аудитын алба

Дэмжсэн:

ШУТИС-ийн харьяа ЕБАС-ийн захирлын зөвлөл
Дарханы Технологийн сургуулийн захирлын зөвлөл

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	4
ЗУРГАА. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ.....	5
НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ.....	6
ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	7
ХАВСРАЛТ 2. БАЙРШИЛ, ХАЯГИЙН МЭДЭЭЛЭЛ.....	8

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05 сарын 02-ны
өдрийн 153 дугаар тушаалын хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 333 дугаарт тушаалын хавсралт "Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам" -ын 3.3 дахь заалт, шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн үйл ажиллагааг зохицуулах журмын 7.5, 7.6 дахь заалтыг тус тус баримтлан ШУТИС-ийн харьяа ЕБАС-д 2023-2024 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг мөрднө.
- 1.2 ШУТИС-ийн харьяа ЕБАС-д элсэн суралцааар хүсэлт гаргагчийн элсэлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль, Дарханы Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль
- 2.2. Тус журмаар зохицуулагдаагүй асуудлыг тус сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1. Боловсролын тухай хууль
- 3.2. Бага, дунд боловсролын тухай хууль
- 3.3. Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам
- 3.4. ШУТИС-ийн харьяа ЕБАС-ийн үйл ажиллагааг зохицуулах журам

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. **Элсэлтийн шалгалт:** Ахлах сургуульд элсэх хүсэлтэй суралцагчдын суурь боловсролын мэдлэг, чадварын түвшнийг тогтоох зорилго бүхий шалгалтыг;
- 4.2. **Бүртгүүлэгч:** Ахлах сургуульд элсэх хүсэлт гаргасан суралцагч;
- 4.3. **Элсэгч:** Хяналтын тоонд багтан элсэх эрхээ баталгаажуулсан бүртгүүлэгчийг;
- 4.4. **Элсэлтийн систем:** Элсэлтийн цахим бүртгэлийн системийг;
- 4.5. **Элсэлтийн комисс:** Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг;
- 4.6. **Элсэлтийн бүртгэл:** Элсэлтийн веб хуудсанд нэвтрэх хувийн мэдээлэл оруулахыг;
- 4.7. **Элсэлт баталгаажуулалт:** Шалгалтад тэнцэн онооны жагсаалтын дагуу хяналтын тоонд багтсан суралцагч сургалтын төлбөрөө төлөн элсэлтээ баталгаажуулах үйл явцыг;
- 4.8. **Хяналтын тоо:** Захирлын зөвлөлөөс баталсан элсүүлэх суралцагчийн тоог;
- 4.9. **Товчилсон үгсийн жагсаалт:**
 - ШУТИС-Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
 - ЕБАС- Ерөнхий боловсролын ахлах сургууль

ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА



5.1. ЕБАС-ийн захирал

- 5.1.1. Элсэлтийн комисс байгуулж удирдлагаар хангаж ажиллана.
- 5.1.2. Элсэлтийн комиссын ажлын төлөвлөгөө, төсвийг батална.
- 5.1.3. Элсэлтийн үйл ажиллагааны явцтай танилцаж санал, зөвлөмж өгнө.
- 5.1.4. Элсэлтийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлантай танилцаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

5.2. Элсэлтийн комисс

- 5.2.1. Элсэлтийн комисс нь захирал, сургалтын менежер, захирлын туслах, шалгалтын материал засч, дүнг нэгтгэх багш нарын бүрэлдэхүүнтэй байна.
- 5.2.2. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.
- 5.2.3. Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
- 5.2.4. Элсэлтийн маркетингийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
- 5.2.5. Элсэлтийн үеийн өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулна.
- 5.2.6. Байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд аливаа байдлаар сөргөөр нөлөөлөх ташаа мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байх, төлөв төвшин, соёлч боловсон харьцааг эрхэмлэх
- 5.2.7. Сургуулийн дүрэм, журам зөрчсөн ямар нэгэн дутагдал гаргаж буй суралцагчдад зохих ёсны шаардлага тавих

ЗУРГАА. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 6.1. Элсэлтийн комиссыг тухайн сургуулийн захирлын тушаалаар батална.
- 6.2. Элсэлтийн комисс нь элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллах бөгөөд тухайн журмаар зохицуулагдаагүй асуудлыг ахлах сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 6.3. Элсэлтийн комисс нь элсэхийг хүсэгчдэд дараах мэдээллийг сургуулийн веб хуудас болон цахим сувгуудаар, элсэлтийг зарлахаас 14-20 хоногийн өмнө мэдээлнэ. Үүнд:
 - 6.3.1. Элсэгчдэд тавигдах шаардлага
 - 6.3.2. Элсэлтийн бүртгэл болон шалгалт зохион байгуулах хугацаа
 - 6.3.3. Сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээлэл
 - 6.3.4. Сургалтын явцад суралцагчдын оролцох оролцоо
 - 6.3.5. Сургалтын төлбөрийн мэдээлэл
- 6.4. БҮРТГҮҮЛЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА
 - 6.4.1. Суурь боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээ 85% ба түүнээс дээш
 - 6.4.2. Инженер техник, технологийн болон зураг-дизайны чиглэлээр суралцах сонирхолтой
- 6.5. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ
 - 6.5.1. Элсэхийг хүсэгчид 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрөөс 2023.06.11-ны өдрүүдээр www.elselt.edu.mn хаягтай веб сайтаар дамжуулан улс орон даяар цахим хэлбэрээр бүртгүүлнэ.
 - 6.5.2. Элсэг нь веб хуудсанд шаардлагатай мэдээллийг оруулж бүртгэлийг баталгаажуулан шалгалтад ирэхдээ бүртгэлийн хуудсаа хэвлэж, төрсний гэрчилгээний хамт авч ирнэ.

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05 сарын 02-ны
өдрийн 27 дугаар тушаалын хавсралт



6.6. НЭМЭЛТ ЭЛСЭЛТ АВАХ

- 6.6.1. Нэмэлт элсэлтэд бүртгүүлэх элсэгчид нь тус журмын 6.3-т заасны дагуу бүртгүүлнэ.
- 6.6.2. Нэмэлт элсэлтийн бүртгэл 2023 оны 8 дугаар сарын 21-нээс 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрүүдэд явагдаж, шалгалтыг 2023 оны 08 дугаар сарын 28-ний өдөр зохион байгуулна.
- 6.6.3. Хичээлийн жилийн хоёр, гуравдугаар улиралд анги дүүргэлтийг нөхөж, энэхүү журамд заасан шаардлагыг хангасан суралцагчийг шилжүүлэн авч суралцуулж болно.

ДОЛОО. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

7.1. Шалгалтын үндсэн зарчим

- 7.1.1 Шалгалтын даалгавар шалгуур түвшинд нь тохирсон, үнэн зөв, суралцагчдад ойлгомжтой, бодитой үнэлэлт, дүгнэлт хийх болон тэдний сэтгэн бodoх чадварыг нээн илрүүлэх боломжтой байх

7.1.2 Шалгалт шударга, ил тод байх

7.1.3 Шалгалт авах хэлбэр нь тодорхой, нийтэд мэдээлэгдсэн байх

7.2. Шалгалтын дэг, шалгалт зохион байгуулах

- 7.2.1. ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн элсэлтийн шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн 4-р байранд зохион байгуулна. Үүнд:

- Математик, физикийн гүнзгийрүүлсэн сургалттай инженерийн ангид: Математик (60 мин), физик (30 мин), эссе бичлэгийн шалгалт (30 мин)
- Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай зураг-дизайны ангид: Математик (60 мин), зургийн ур чадварын шалгалт (90 мин), эссе бичлэгийн шалгалт (30 мин)
- Эссе бичлэгийн үгийн тоо 100-120

Дарханы Технологийн сургуулийн харьяа Ахлах сургуулийн элсэлтийн шалгалтыг 05 сарын 27-ны өдөр ДаТС-ийн хичээлийн 2-р байранд зохион байгуулна.

- Шалгалт Математик (60 мин), Англи хэл (40 мин), Монгол хэл (40 мин) хичээлүүдээр авна.

7.3. Шалгалтын сэдэв боловсруулах багийг томилох, нууцлалыг хадгалан ажиллах үүргийг элсэлтийн комисс хариуцна.

7.4. Шалгалтын сэдвийг тухайн хичээлүүдийн суурь боловсролын агуулгын хүрээнд боловсруулна.

7.5. Элсэлтийн комисс шалгалтын сэдвийг шалгалт эхлэхээс нэг цагийн өмнө шалгуулагчдын тоогоор хувилж бэлтгэнэ.

7.6. Шалгалт эхлэхээс хагас цагийн өмнө комиссын гишүүд шалгуулагчдыг бүртгэлийн хуудастай тулган ангиудад хуваарилан оруулж хянагч багш нарыг томилно.

7.6.1. Хянагч багш шалгалтын дэгийг уншиж танилцуулна.

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05 сарын 02-ны
өдрийн 14/53 дугаар тушаалын хавсралт

- 7.6.2. Хянагч багш шалгалтын материалыг тарааж, шалгалтыг эхлүүлнэ.
- 7.6.3. Шалгалтын хугацаа дуусмагц хянагч багш шалгуулагчдын материалыг шифрлэж, хурааж авна.
- 7.6.4. Хянагч багш шалгалтын явцын талаар тэмдэглэл хөтөлнө.
- 7.6.5. Шалгалтын явцад шалгуулагч нь дэг зөрчвөл шалгалтаас шууд чөлөөлнө.
- 7.7. Шалгалтын материалыг томилогдсон багш засч, шалгалтын хуудас болон оноог комисст хүлээлгэн өгнө.
- 7.8. Элсэлтийн комисс шалгалт зохион байгуулагдсан өдөр шалгалтын оноог сургуулийн вэбсайт, facebook хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.
- 7.9. Элсэгч нь шалгалтын оноо, үр дүнтэй холбоотой материалыг нягтлан шалгах хүсэлт гаргаж дэлгэрэнгүй танилцах боломжтой.

НАЙМ. ЭЛСЭЛТИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

- 8.1. Элсэлтийн шалгалтын оноогоор жагсаан хяналтын тоонд багтсан суралцагчдыг элсүүлнэ.
- 8.2. Төрөлжсөн болон олон улсын олимпиадад эхний 10 байр эзэлсэн бол амжилтыг харгалзан шалгалтгүйгээр шууд элсүүлнэ.
- 8.3. Элсэх болзол хангаж, хяналтын тоонд багтсан элсэгчдийг 2023 оны 06-р дугаар сарын 13-наас 2023 оны 06 дугаар сарын 19 өдрүүдэд ахлах сургуулийн хичээлийн байрны 306 тоот өреөнд сургалтын менежер бүртгэж авна. Бүртгүүлэхдээ доорх материалыг бүрдүүлж ирнэ. Үүнд:
- Сурагчийн хувийн хэрэг (шилжүүлэг хийлгэсэн байх)
 - Суурь боловсролын гэрчилгээ
 - Төлбөр төлсөн баримт
- 8.4. Суралцагчийн материалыг хувийн хэрэгт бүрдүүлж төгсөх үед хүлээлгэж өгнө. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.
- 8.5. Элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох аливаа маргаан, зөрчлийг бичгээр хүлээн авч, шийдвэрлэнэ.



ШУТИС-ийн захирлын 2023 оны 05 сарын 05-ны
өдрийн 153 дугаар тушаалын хавсралт

ХАВСРАЛТ 1.ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [I] – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)				
				ЭК	З	З Г	С/ М	Ч Б
1	Элсэлтийн журам		ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан журам		A	C	C	R
2	ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан журам		Сургуулийн танилцуулга, элсэлтийн мэдээ, мэдээлэл	A,R			R	
3	Элсэгчдэд тавигдах шаардлага		Бүртгэлийн хураамж, элсэхийг хүсэгчдийн бүртгэл	R	A	C		
4	Элсэхийг хүсэгчдийн бүртгэл		Шалгалтын дүн	R	I		A	R
5	Шалгалтын дүн		Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт	R/A	C		I	C
6	Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт		Веб хуудас дахь элсэлтийн баталгаажуулалт ын бүртгэлийн мэдээлэл	R/A	C		I	C
7	Элсэлтийн баталгаажуулах бүртгэл		Бичиг баримт болон төлбөр төлсөн баримтын хамт бүртгэл баталгаажуулах	R/A	C		I	C
8	Суралцагчийн код		Сургалтын гэрээ		A		R	C
9	Сургалтын гэрээ		Суралцагчаар батлах тухай тушаал		A	C	R	C

*ЭК-Элсэлтийн комисс

*З-ЕБАС-ийн захирал

*З3Г-Захирлын зөвлөлийн гишүүн Б/А-Багш, ажилтан, *ЧБ-Чанарын баг



Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар холбогдон авна.

ШУТИС-ийн харьяа ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬ

Утас: 77110208, 99721372, 96649661

e-mail: highschool@must.edu.mn

Веб хаяг: <http://www.musthighschool.mn/mn/>

Пейж хуудас: ШУТИС Ахлах сургууль

Сургуулийн байршил, хаяг: , ШУТИС-ийн 4-р байр, 8-р хороо, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14191

ДАРХАНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН харьяа АХЛАХ СУРГУУЛЬ

Утас: 99987474, 80982848

e-mail: tis.darkhan@esrp.edu.mn

Веб хаяг: http://stda.edu.mn/?page_id=2732

Пейж хуудас: Дархан-Уул аймаг дахь ШУТИС-ийн харьяа Ахлах сургууль

Сургуулийн байршил: ДаТС-ийн хичээлийн 2-р байр, 15-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, Монгол, 45000